







Улаанбаатар хот дахь Бүгд Найрамдах Чех Улсын Элчин сайдын яам

1. БЕЛТ & СЕРВИС ХХК

БЕЛТ & СЕРВИС ХХК нь чанартай удаан эдэлгээ бүхий төрөл бүрийн даавуун болон ган утсан туузан дамжлагуудыг нийлүүлж бүх сервис үйлчилгээг үзүүлдэг. ОХУ болон Казахстанд энэ чиглэлээр нэлээд олон төслүүдийг хэрэгжүүлсэн арвин туршлагатай компани юм. Үүнээс гадна уул уурхайн технологийн иж бүрэн тоног төхөөрөмж, цахилгаан соронзон тусгаарлагчууд, хөмрөгч мөн түүнчлэн өргөн сонголт бүхий үйлдвэрлэлийн чанартай гэрэлтүүлгийг ч санал болгодог.

Доорх зурагнаас галд, хүйтэнд, химийн бодисонд тэсвэртэй мөн налуу, огцом тээвэрлэлт хийх зориулалт бүхий төрөл бүрийн туузан дамжлагуудыг харж болно.





Дэлгэрэнгүй мэдээллийг: <http://www.beltservice.cz/en/home/>

2. ИНКО ИНЖЕНИЕРЕНГ

Тус компани нь ил болон далд уурхайн олборлолтын босоо, налуу болон хэвтээ тээвэрлэлтийн техник, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл явуулдаг. Төрөл бүрийн бүтэц, 2 x 5500 кВ хүртэлх хүчин чадал бүхий үрэлтийн дисктэй/ frictional disc/ болон барабантай /drum hoists/ тоног төхөөрөмжүүд, тэргэнцрүүд, ороомгийн дамарнууд, уурхайн дохиоллын систем, харилцаа холбооны систем, бүрэн автомат ачиж буулгах тэргэнцэр, хөдөлгүүртэй уурхайн салхивчууд гэх мэт олон төрлийн тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрлэдэг бөгөөд зураг төсөл боловсруулахаас эхлээд үйлдвэрлэх, суурилуулах, сургалт явуулах, сервис үйлчилгээ үзүүлэх бүрэн цогц үйлчилгээг үзүүлдэг арвин туршлагатай компани юм.

Үйлдвэрлэлийн гол сортиментууд

□ Үрэлтийн дисктэй олборлолтын тоног төхөөрөмж



- нэгээс найман олс бүхий татах системтэй – үрэлтийн дискний ердийн диаметр нь 7 m хүртэл
- 250 kV - аас эхлээд 2 x 5500 kV хүчин чадал бүхий нэг буюу хоёр мотортой хөдөлгүүрүүд
- Нэг чиглэлийн болон синхрон бус хөдөлгүүртэй
- статик зонхилох хүч 45 kH - 600 kH
- ашигтай ачаалал 5000 kg до 60000 kg
- олборлох хурд 6 m/c - 20 m/c

□ Барабантай олборлолтын тоног төхөөрөмж



- нэг болон хоёр барабантай – ердийн диаметр 6,5 m хүртэл
- 250 kV - аас эхлээд 2 x 5500 kV хүчин чадал бүхий нэг буюу хоёр мотортой хөдөлгүүрүүд

- Нэг чиглэлийн болон синхрон бус хөдөлгүүртэй
- статик зонхилох хүч 55 кН - 435 кН
- ашигтай ачаалал 4000 кг до 25000 кг
- олборлох хурд 6 м/с - 16 м/с

□ Олборлолтын жижиг төхөөрөмжүүд



- нэг болон хоёр барабантай үрэлтийн диск бүхий – ердийн диаметр 2,5 m хүртэл
- 70 кВ - 250 кВ хүчин чадал бүхий нэг мотортой
- давтамжтай хөрвүүлэгч бүхий синхрон бус хөдөлгүүртэй
- олсны статик татах хүч 130 кН хүртэл
- ашигтай ачаалал 7500 кг
- олборлох хурд 3 м/с

□ Хөдөлгүүрийн, удирдлагын, тормосны хэсэгчилсэн системүүд болон бусад:

- нэг чиглэлтэй синхрон бус хөдөлгүүрүүд
- хагас дамжуулагч хөрвүүлэгчийн систем ВАРИАНТ
- EMADYN микропроцессорын тохируулагчтай MODULEX тохируулгын систем
- микропроцессорын систем бүхий удирдлагын хуваарилагч төхөөрөмж
- туслах хөдөлгүүрийн хуваарилагч төхөөрөмж
- VN хуваарилагч төхөөрөмж
- дискэн тормозны нэгжүүд НРВ170 ба НРВ200
- НР5К, НР7К, НР9К цуврал аваарын тормозны горим бүхий тогтмол тормозлох тохиргоотой цахилгаан гидравлик тормозны системүүд
 - аваарын тормозны горим бүхий 2 автомат тохиргоотой цуврал НР13К, НР15К цахилгаан гидравлик тормозны систем
 - цахилгаан гидравлик тормозны систем Frenomatic НР11К, НР17К Reprimatic аваарын горим нь тогтмол (туйл болон ачааллын хэмжээнээс хамааралгүй)
 - Sistonіc PR6K цахилгаан пневматик тормозны систем
 - тосолгооны Tribonic III цахилгаан гидравлик системийн цуврал
 - нэгдсэн төв системтэй удирдлагын пулт
 - агааржуулсан болон дуу намжаагчаар тоногдсон машинчийн кабин

□ Уурхайн дохиоллын систем

- нөөцийн шилэн кабелиар холбосон сүлжээ

- Микропроцессорон удирдлага
- тэсэрч дэлбэрэхгүйгээр хийгдсэн

□ **тээвэрлэлтийн савнаас харилцах систем**

- хэл ярианы болон дохион харилцаа
- тээвэрлэлтийн савнаас олборлолтын тоног төхөөрөмжөө удирдах боломж
- тэсэрч дэлбэрэхгүйгээр хийгдсэн

□ **Сараалжууд /хашлагатай зориулалтын тавцан/**

- нэг давхраас дөрвөн давхар хүртэл байж болно.
- уурхайн машины тусламжтайгаар хүн болон материал тээвэрлэхэд зориулагдсан
- ашигтай ачаалал 2500 кг - 16000 кг (том хэмжээний сараалж 23000 кг)

□ **Олборлосон шороогоо хийх тэргэнцэр сав**

- хатуу чанарын гангаар хийгдсэн нэг болон хоёр корпустай
- үйлчлүүлэгчдийн хүсэлтээр савны төрөл бүрийн хавхагнууд,
- ашигтай ачаалах чадвар 1500 кг - 50000 кг

- Тэргэнцрийг дүүргэх болон суллах бүрэн автомат станцууд
- Олборлолтын машиныг түлхэх тоног төхөөрөмж
- Олборлолтын машинуудад зориулсан төмөр зам, хөмрүүлэх станцын хамт
- Хөдөлгөөнгүй болон уян хатан дугуйнууд
- Төрөл бүрийн олснууд
- Олс татаж тэнцвэржүүлэгч
- Олсны таталтын хүчийг хэмжих систем
- Олборлолтын тоног төхөөрөмжийн олсыг солиход туслах материалууд
- Нөөцийн болон бусад савнууд таглааны хамт
- Гинжнүүд, алхам алхмаар түлхэх төхөөрөмж
- Туузан болон нэмэлт дамжуулагчид
- Уурхайн салхивч хөдөлгүүр болон дамтамжийн тохируулагчийн хамтаар

Дэлгэрэнгүй мэдээллийг: <http://www.incoengineering.cz/>

3. ЭНЭЛЕКС

1991 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн цэвэр чехийн хөрөнгө оруулалттай компани юм. Үйл ажиллагаагаа нь гол төлөв уул уурхайн болон эрчим хүчний салбарын тусгай цахилгаан тоног төхөөрөмж, хэрэгслийн үйлдвэрлэлд чиглэгдсэн.

Үйлдвэрлэлийнх нь программын бас нэг бүтээгдхүүнд цахилгаан станц, дулааны станц, уурын зуух, үйлдвэрийн шатаах цех зэргийн нүүрсний үнсжилтийг хэмжигч болон хүчилтөрөгчийн анализатор орно. Мөн түүнчлэн хүнд хэцүү ажлын байранд зориулсан камерын систем үйлдвэрлэж суурилуулахаас гадна цацрагаас хамгаалах үйлчилгээг ч явуулдаг.




Дэлгэрэнгүй мэдээллийг: <http://www.enelex.cz/en/firma.htm>

4. РПС ОСТРАВА ХК

РПС Острава ХК нь 1997 оноос эхлэн чехийн болон гадаадын зах зээл дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа инженерчлэлийн компани юм. Тус компани нь инженерчлэлийн үйл ажиллагаа, төсөл боловсруулалт, барилга байгууламж, технологийн цогц хангамж, эрчим хүчний салбарт ган бүтэц нийлүүлэх, биомаса боловсруулах, ашигт малтмал цэвэршүүлэх үйлдвэр болон коксын үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Хийж буй ажлынх нь чанар хамгийн төвөгтэй хөрөнгө оруулалтын төслүүдийг ч аливаа асуудалгүй хэрэгжүүлэх боломжоор хангадаг. Компаний бодлогын нэг хэсэг бол үйлчлүүлэгчиддээ тэдний аливаа асуудлыг шийдэхэд цогц, чанартай үйлчилгээ үзүүлэх явдал юм.



Дэлгэрэнгүй мэдээллийг: <http://www.rpsostrava.cz/en>

5. ТМ МАШИНЕРИ ХК

ТМ машинери ХК 2003 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд өнөөгийн байдлаар Чех улсад уул уурхайн салбарын цорын ганц олборлолтын техник технологийг санал боловсруулахаас эхлээд үйлдвэрлэх, нийлүүлэх, угсрах, үйл ажиллагаанд оруулах хүртэл иж бүрнээр нь хийх боломжтой компани юм. Тус компани Өмнөд Моравын энэхүү уул уурхайн чиглэлийн үйлдвэрлэлийн 80 гаруй жилийн уламжлалтай уялдуулан үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ.

Үйлдвэрлэлийн сортимент:

- МБ серийн олборлогч комбайнууд
- СЗК төрөл бүрийн туузан дамжлагууд
- олборлох орчны аюулгүй байдлыг хангах гидравлик хануудыг удирдлагын хамт
- солих эд ангийн үйлдвэрлэл
- олборлолтын автомат тоног төхөөрөмжийн бүх цахилгаан хэрэгслүүд гэх мэт.

Түүнчлэн сервис үйлчилгээ сургалт явуулдаг.


Бүтээгдхүүнийхээ 95% орчмыг гадагшаа экспортонд гаргадаг. Ихэнхдээ уул уурхайн иж бүрэн тоног төхөөрөмж гаргаж байгаа бөгөөд дийлэнх хувийг Украин, ОХУ эзэлж байна. Мөн Азийн орнуудас Вьетнам руу гаргаж байгаа.



Дэлгэрэнгүй мэдээллийг: <http://www.tmachinery.cz/en/>

6. ФЕРРИТ ХХК

Феррит ХХК нь 1993 онд байгуулагдсан бөгөөд дүүжин, араат, төмөр замт, тороост зэрэг уурхайн ачаа тээвэрлэх системүүдийг өргөх нэмэлт төхөөрөмжийн хамт үйлдвэрлэдэг төдийгүй үйлчлүүлэгчдээ олон үйлдэлт ачаа ачигч уул уурхайн тусгай зориулалтын машин механизмаар хангах, зураг төсөл боловсруулах, уул уурхайг иж бүрэн тоног төхөөрөмжөөр тоноглохоос гадна холбогдох бусад төрлийн ажлыг хийж гүйцэтгэдэг. Борлуулалт, бүтээгдхүүний дэвшилт, үйлдвэрлэл, хангамж, тээвэр зэрэг тасгууд, мөн агуулах, туршилтын полигон багтаасан компаний төв Чех улсын Фридек Мистек хотын дэргэдэх Старе Место хотод оршдог. Худалдаа, нийлүүлэлт, засвар үйлчилгээг үр ашигтай болоод үр дүнтэй байлгах үүднээс ОХУ, Польш, Украин, Казахстан, Словак, Хятад зэрэг орнуудад охин компаниа байгуулсан.





Дэлгэрэнгүй мэдээллийг: <http://www.ferrit.cz/en/about-company/>

7. ПЕРМОН ХХК

Анх үйлдвэрийн суурийг 1824 онд Бороунка голын эрэг дээр ханхүү Карел Эгон II von Fürstenberg тавьж байсан түүхтэй юм байна. Түүхийн олон шалгуурыг дамжсаар 1980 онд бие даасан төрийн өмчит Пермон компани үүсгэн байгуулагджээ. 1994 онд ноён В. Коуделка хувьчилж авснаар Пермон ХХК байгуулагджээ. 2013 оны эцсээр В. Коуделкаг нас эцэслэсний дараа түүний өв залгамжлагчид компаниа KASEY Investment Holding SE компанид худалдаж өнөөг хүртэл пермон брендийн цуврал хийн болон гидравлик багаж төхөөрөмжийг үйлдвэрлэж дэлхийн зах зээлд нийлүүлсээр байна. Тус компани бутлагч, цавчигч, нураах, өрөмдөх зэрэг олон төрлийн хий болон гидравлик хөдөлгүүр бүхий алхнуудыг үйлдвэрлэдэг.





Дэлгэрэнгүй мэдээллийг: <http://www.permon.cz/en/company>

8. ЧЕХИЙН ОЛБОРЛОЛТЫН ТЕХНИК НЭГДЭЛ

Чехийн олборлолтын техник нэгдэл нь чехийн удаан жилийн уул уурхайн олборлолтын уламжлалтай уялдуулан үйл ажиллагаагаа явуулж буй томоохон компаниудыг эгнээндээ багтаасан байгууллага бөгөөд гол зорилго нь одоогийн байдлаар арай тэдний хувьд нээгдэж амжаагүй байгаа зүүн европын зах заалд нэвтэрч түүнчлэн ОХУ, Украин гэх мэт томоохон ашигт малтмалын олборлолт хийдэг улсуудын компаниудтай худалдааны харилцаа үүсгэн хамтарч ажиллах явдал юм. Гишүүн компаниуд нь уул уурхайн чиглэлээр зураг төсөл боловсруулахаас эхлээд, тоног төхөөрөмж үйлдвэрлэх, нийлүүлэх, суурилуулах, сургалт явуулах гэх мэтээр иж бүрэн үйлчилгээ явуулах бүрэн боломжтой, арвин туршлагатай билээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг: <http://www.cdte.cz/en/about/>